

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/144/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/179

танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.БУЛГАНЧИМЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2023 оо/ALBAN BICHIG
19020547

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,991,297.57	168,167,038.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	5,110,078.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	5,110,078.71
3121	Төгрөг	00.00	5,110,078.71
31211	Төрийн сангийн харилцах	00.00	5,110,078.71
33	АВЛАГА	00.00	93,164,287.63
335	Бусад авлага	00.00	93,164,287.63
3351	Байгууллагаас авах авлага	00.00	93,164,287.63
35	БАРАА МАТЕРИАЛ	54,991,297.57	69,892,672.21
351	Түүхий эд материал	28,345,593.85	45,079,184.49
35110	Тусгай зориулалттай материал	18,688,281.50	34,970,398.34
35130	Эм боох материал	9,657,312.35	10,108,786.15
354	Хангамжийн материал	26,645,703.72	24,813,487.72
35410	Бичиг хэргийн материал	336,200.00	00.00
35420	Аж ахуйн материал	18,499,350.72	23,131,850.72
35430	Сэлбэг хэрэгсэл	4,330,000.00	00.00
35460	Хүнсний материал	1,278,653.00	180,137.00
35470	Бусад хангамжийн материал	2,201,500.00	1,501,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	734,413,744.75	800,250,904.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	734,413,744.75	800,250,904.49
392	Биет хөрөнгө	733,013,744.75	798,850,904.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	695,720,497.30	695,720,497.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,357,944.80	-35,036,917.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	54,102,143.00	50,070,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,632,143.12	-22,118,333.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,805,018.05	189,061,612.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-94,250,364.80	-101,655,752.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,777,344.86	54,160,936.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,063,361.74	-32,342,694.42
39217	Ном	912,556.00	991,556.00
393	Биет бус хөрөнгө	1,400,000.00	1,400,000.00
39301	Программ хангамж	985,000.00	985,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-985,000.00	-985,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,400,000.00	1,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	789,405,042.32	968,417,943.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	789,405,042.32	968,417,943.04
51	Засгийн газрын хувь оролцоо	789,405,042.32	968,417,943.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	606,283,482.44	606,283,482.44
51101	Өмч: - төрийн	606,283,482.44	606,283,482.44
512	Хуримтлагдсан үр дүн	183,121,559.88	362,134,460.60
51210	Өмнөх үеийн үр дүн	183,121,559.88	183,121,559.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	179,012,900.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	789,405,042.32	968,417,943.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	552,320,695.97	1,276,480,643.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,112,068.97	413,637,518.78
120	Нийтлэг татварын бус орлого	42,112,068.97	413,637,518.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,112,068.97	413,617,018.78
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,112,068.97	413,617,018.78
120009	Бусад орлого	00.00	20,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,690,627.00	409,800,825.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,518,000.00	453,042,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,051,877.00	332,713,055.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,130,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,921,877.00	322,802,155.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,890,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,577,600.00	36,532,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,577,600.00	36,532,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	50,061,150.00	40,554,970.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	50,061,150.00	40,554,970.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	551,328,164.34	1,097,467,743.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	551,328,164.34	1,097,467,743.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	550,089,330.79	1,096,063,753.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,668,485.04	358,461,822.68
210101	Үндсэн цалин	223,433,975.20	229,549,786.61
210102	Нэмэгдэл	88,087,362.04	89,634,956.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,014,000.00	4,840,000.00
210104	Урамшуулал	19,133,147.80	34,437,079.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,143,587.80	49,432,192.87
210201	Тэтгэврийн даатгал	31,497,799.99	35,305,631.01
210202	Тэтгэмжийн даатгал	3,471,697.15	3,682,965.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,760,557.68	2,884,809.27
210204	Ажилгүйдлийн даатгал	673,957.61	687,162.82
210205	Эрүүл мэндийн даатгал	6,739,575.37	6,871,624.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,167,835.40	33,943,131.20
210301	Гэрэл, цахилгаан	1,852,045.40	3,132,549.20
210302	Түлш, халаалт	27,030,790.00	30,560,582.00
210303	Цэвэр, бохир ус	285,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,122,510.00	29,530,750.00
210401	Бичиг хэрэг	2,996,050.00	3,332,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,382,600.00	21,376,950.00

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,421,560.00	1,908,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,322,300.00	2,912,500.00
2105	Нормативт зардал	69,965,267.47	402,089,070.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,018,182.47	389,340,754.48
210502	Хоол, хүнс	9,947,085.00	12,748,316.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,545,900.00	18,409,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	240,500.00	4,042,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,343,500.00	5,436,200.00
210604	Урсгал засвар	961,900.00	8,930,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,339,000.00	2,232,000.00
210702	Дотоод албан томилолт	1,339,000.00	2,232,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	71,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,633,245.08	201,965,786.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,247,568.85	162,675,188.21
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,385,676.23	39,290,597.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,238,833.55	1,403,989.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,238,833.55	395,989.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	992,531.63	179,012,900.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	992,531.63	179,012,900.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	606,283,482.44	00.00	183,121,559.88	789,405,042.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	606,283,482.44	00.00	183,121,559.88	789,405,042.32
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	606,283,482.44	00.00	183,121,559.88	789,405,042.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	606,283,482.44	00.00	183,121,559.88	789,405,042.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	179,012,900.72	179,012,900.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	606,283,482.44	00.00	362,134,460.60	968,417,943.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	510,208,627.00	770,408,425.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	20,500.00	
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	20,500.00	
120009	Бусад орлого	00.00	20,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,208,627.00	770,387,925.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,518,000.00	453,042,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,051,877.00	240,257,855.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,720,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,130,000.00	300,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,921,877.00	230,346,955.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	7,890,900.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,577,600.00	36,532,800.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,577,600.00	36,532,800.00	
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	50,061,150.00	40,554,970.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	50,061,150.00	40,554,970.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	500,704,633.00	745,878,546.29	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,704,633.00	745,878,546.29	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,465,799.45	744,474,556.49	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,668,485.04	358,461,822.68	
210101	Үндсэн цалин	223,433,975.20	229,549,786.61	
210102	Нэмэгдэл	88,087,362.04	89,634,956.61	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,014,000.00	4,840,000.00	
210104	Урамшуулал	19,133,147.80	34,437,079.46	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,143,587.81	49,432,192.11	
210201	Тэтгэврийн даатгал	31,497,800.00	35,305,631.01	
210202	Тэтгэмжийн даатгал	3,471,697.15	3,682,965.66	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,760,557.68	2,884,809.27	
210204	Ажилгүйдлийн даатгал	673,957.61	687,162.42	
210205	Эрүүл мэндийн даатгал	6,739,575.37	6,871,623.75	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,743,785.40	33,943,131.20	
210301	Гэрэл, цахилгаан	3,447,794.40	3,132,549.20	
210302	Түлш, халаалт	29,010,991.00	30,560,582.00	
210303	Цэвэр, бохир ус	285,000.00	250,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	27,998,010.00	27,462,550.00	

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,996,050.00	2,996,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,382,600.00	19,757,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,822,060.00	1,908,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,797,300.00	2,799,500.00
2105	Нормативт зардал	43,938,711.20	96,827,510.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,938,711.20	85,827,710.50
210502	Хоол, хүнс	11,000,000.00	10,999,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,455,700.00	9,444,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	240,500.00	2,045,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,198,500.00	5,199,200.00
210604	Урсгал засвар	2,016,700.00	2,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,339,000.00	2,232,000.00
210702	Дотоод албан томилолт	1,339,000.00	2,232,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,503,500.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	71,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,675,020.00	166,671,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,675,020.00	166,671,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,238,833.55	1,403,989.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,008,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,238,833.55	395,989.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,238,833.55	395,989.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,503,994.00</u>	<u>24,529,878.71</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>9,503,994.00</u>	<u>19,419,800.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>9,503,994.00</u>	<u>19,419,800.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	9,503,994.00	19,419,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,503,994.00	19,419,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-9,503,994.00</u>	<u>-19,419,800.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	5,110,078.71
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	5,110,078.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	541,891,900.0	524,650,822.5	17,241,077.5	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,891,900.0	524,650,822.5	17,241,077.5	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,891,900.0	524,650,822.5	17,241,077.5	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,449,500.0	358,461,822.7	14,987,677.3	96.0
210101	Үндсэн цалин	233,692,700.0	229,549,786.6	4,142,913.4	98.2
210102	Нэмэгдэл	98,150,900.0	89,634,956.6	8,515,943.4	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,552,000.0	4,840,000.0	1,712,000.0	73.9
210104	Урамшуулал	35,053,900.0	34,437,079.5	616,820.5	98.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,415,700.0	49,432,192.1	983,507.9	98.0
210201	Тэтгэврийн даатгал	35,477,700.0	35,305,631.0	172,069.0	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,734,500.0	3,682,965.7	51,534.3	98.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,987,600.0	2,884,809.3	102,790.7	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	746,900.0	687,162.4	59,737.6	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,469,000.0	6,871,623.8	597,376.3	92.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,332,800.0	33,943,131.2	389,668.8	98.9
210301	Гэрэл, цахилгаан	3,447,800.0	3,132,549.2	315,250.8	90.9
210302	Түлш, халаалт	30,600,000.0	30,560,582.0	39,418.0	99.9
210303	Цэвэр, бохир ус	285,000.0	250,000.0	35,000.0	87.7
2104	Хангамж, бараа материалын зардал	27,150,000.0	27,054,600.0	95,400.0	99.6
210401	Бичиг хэрэг	3,000,000.0	2,996,500.0	3,500.0	99.9
210402	Тээвэр, шатахуун	19,350,000.0	19,350,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	1,908,600.0	91,400.0	95.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.0	2,799,500.0	500.0	100.0
2105	Нормативт зардал	33,943,900.0	33,928,456.5	15,443.5	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,943,900.0	22,928,656.5	15,243.5	99.9
210502	Хоол, хүнс	11,000,000.0	10,999,800.0	200.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,900,000.0	10,899,200.0	800.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.0	3,500,000.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,200,000.0	5,199,200.0	800.0	100.0
210604	Урсгал засвар	2,200,000.0	2,200,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.0	2,232,000.0	768,000.0	74.4
210702	Дотоод албан томилолт	3,000,000.0	2,232,000.0	768,000.0	74.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000.0	8,699,420.0	580.0	100.0

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000.0	8,699,420.0	580.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	541,891,900.0	530,130,070.0	11,761,830.0	97.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	453,042,300.0	453,042,300.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	453,042,300.0	453,042,300.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,532,800.0	36,532,800.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	36,532,800.0	36,532,800.0	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,316,800.0	40,554,970.0	11,761,830.0	77.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	52,316,800.0	40,554,970.0	11,761,830.0	77.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,110,078.7	(5,110,078.7)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.0	24.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	240,251,534.00	240,251,534.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	240,251,534.00	240,251,534.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,243,534.00	239,243,534.00
2104	Хангамж, бараа материалын зардал	407,950.00	407,950.00
210402	Тээвэр, шатахуун	407,950.00	407,950.00
2105	Нормативт зардал	64,399,054.00	64,399,054.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,399,054.00	64,399,054.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,436,530.00	174,436,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	174,436,530.00	174,436,530.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	1,008,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	240,257,855.00	240,257,855.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,257,855.00	240,257,855.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,720,000.00	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,346,955.00	230,346,955.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,890,900.00	7,890,900.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет болон биет бус хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэж, хөрөнгийн шамшигдал үүсгэхгүй ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын даргын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/09 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган батлуулж, дотоод үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан байна.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 541,891.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,128.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,096.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 541,891.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 530,130.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 97.8 хувийг авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 240,251.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 745,878.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 15,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 70,509.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,539.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 79.0 мянган төгрөгийн ном, нийт 105,127.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 19,419.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 82,165.5 мянган төгрөгийн, дотоод шилжүүлгээр 3,542.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 327,909.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 271,610.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 584,617.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 93,164.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь ЭМДЕГ-аас авах санхүүжилтийн авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 5,110.1 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 69,892.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 800,250.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	5,110.1	5,110.1
Авлага	-	93,164.3	93,164.3
Урьдчилгаа			-
Бараа материал	54,991.3	69,892.7	14,901.4
Үндсэн хөрөнгө	734,413.7	800,250.9	65,837.2
Нийт хөрөнгө	789,405.0	968,417.9	179,012.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	789,405.0	968,417.9	179,012.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	789,405.0	968,417.9	179,012.9

Бараа материалын дансны үлдэгдэл 69,892.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 14,901.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 800,250.9 мянган төгрөг болж 65,837.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 968,417.9 мянган төгрөг болж 179,012.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 541,891.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 541,891.9 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 541,891.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 453,042.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 36,532.8 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 40,555.0 мянган төгрөгийн, нийт 530,130.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 524,650.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, 369.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 5,110.1 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524,650.8 мянган төгрөг буюу 96.8 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 240,251.5 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 239,243.5 мянган төгрөгийг, урсгал шилжүүлэгт 1,008.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 15,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 70,509.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,539.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 79.0 мянган төгрөгийн ном, нийт 105,127.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 19,419.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 82,165.5 мянган төгрөгийн, дотоод шилжүүлгээр 3,542.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулгахад харилцагч байгууллагатай хийсэн 39,223.2 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүйг завсрын аудитаар илрүүлж, жилийн эцсээр зөрчлийг арилган ажилласан. Борнуур сумын Эргэлтийн эмийн сан нь 99,193.9 мянган төгрөгийн эмийн борлуулалтын орлогыг и-баримтаар баталгаажуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 5,781.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 75 нэр төрлийн 73,190.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 4 нэр төрлийн 985.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, тайлант хугацаанд бэлтгэсэн 2 нэр төрлийн 567.5 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэж, бараа материалын орлогоор хүлээн авсан даруй зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 136 мэдээллийг хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,470.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,405.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 76,550.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 1 алдааг залруулж, 1,807.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 74,742.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 1 алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнагдсан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,807.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 23 албан хаагчид вакцины урамшуулал цалин олгохдоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас гарт олгох урамшуулалт цалинг 1,807.6 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 136 мэдээллийг хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага

өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 75 нэр төрлийн 73,190.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 4 нэр төрлийн 985.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет болон биет бус хөрөнгийг шийдвэрлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд бэлтгэсэн 2 нэр төрлийн 567.5 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэж, бараа материалын орлогоор хүлээн авсан даруй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолын 4.6-д “Үндсэн хөрөнгийн дансанд НББОУС-ын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ”, УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж, хөрөнгийн шамшигдал үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв	5	76,550.4	1	-	1	1,807.6	1	-	2	74,742.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn